

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2023 оны
12 дугаар сарын 27-ны өдрийн 1201 дугаар
тушаалын хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан
шинэчлэн боловсруулсан
- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо: _____

Дагаж мөрдөх огноо: _____

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо: _____

2023.12.27

Байгууллагын нэр:

Цагдаагийн ерөнхий газар

Албан тушаалын нэр:

Хүний их эмч

Ажлын цаг:

8 цаг

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Нэгжийн нэр:

Алба, нэгж, нутаг дэвсгэрийн цагдаагийн
байгууллага

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

ТТ-6-8

Ажлын байрны албан ёсны байршил:

Алба, нэгж, нутаг дэвсгэрийн цагдаагийн
байгууллагын байр

Онцгой нөхцөл:

Гал түймэр, хүн, малын гоц халдварт өвчин гарсан, гэнэтийн болон бусад аюул тохиолдсон, нийтийн эмх замбараагүй байдал үүссэн, террорист халдлага, онц болон дайны байдал зарласан, онц ноцтой гэмт хэрэг үйлдэгдсэн зэрэг зайлшгүй тохиолдолд өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллах.

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ:

Албан тушаалын зорилго:

Монгол Улсын хууль, тогтоомж, удирдлагын тушаал, шийдвэрийг хэрэгжүүлж, Алба хаагчдын эрүүл мэндийг сахин хамгаалах, эрүүл, ая тухтай орчин нөхцөлд ажиллахад нь үйл ажиллагааг чиглүүлж, тэдэнд эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээг зохих түвшинд үзүүлж, эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх.

1. Алба хаагч, ажилчдын эрүүл мэндийг сахин хамгаалах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх;
2. Эмнэлгийн эрүүл ахуй, халдвар хамгааллын талаар мэргэжлийн байгууллагуудаас гарсан тушаал, дүрэм журам, зааврыг баримтлан ажиллах;
3. Эмнэлгийн 1 дүгээр шатлалын тусламж үйлчилгээг мэргэжлийн түвшинд үзүүлэх;
4. Эмнэл зүйн эд аж ахуйн бүрэн бүтэн байдалд хяналт тавьж, эм тариа, ороох боох материалыг байнгын бэлэн байдалд байлгаж хэрэгцээнд тулгуурлан нөхөн хангалт хийх;
5. Бие бүрэлдэхүүнд мэргэжлийн болон эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг хариуцан зохион байгуулах;
6. Хууль тогтоомж, дүрэм, журмаар хүлээлгэсэн албан тушаалын зорилго, зорилтод нийцсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах –Т Харилцан гүйцэтгэх-Г Хянах-Х Шийдвэрлэх-Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	<p>1.1. Долоо хоног, сар, жилээр ажлаа төлөвлөж батлуулан, өдөр бүр хийсэн ажлын тэмдэглэл хөтөлж долоо хоног, хагас, бүтэн жилээр хийсэн ажлаа тайлагнах, анхан шатны бүртгэлийг хөтлөхдөө холбогдох эрх зүйн актуудыг хэрэгжүүлэн ажиллах</p> <p>1.2. Бие бүрэлдэхүүнийг жилд 1-ээс доошгүй удаа мэргэжлийн байгууллагаар эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг хийлгэх, мөн хяналтын үзлэгийг тогтмол хийж шаардлагатай алба хаагч ажилтныг диспансерын хяналтад авах, эрүүлжүүлэх ажил хийх;</p> <p>1.3. Архаг суурь өвчтэй алба хаагч, ажилтныг хяналтад авах;</p> <p>1.4. Алба хаагч, ажилтанд өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх дадлага, сургалтыг зохион байгуулах.</p>	Алба хаагч, ажилчдын дундах өвчлөлтийг цаг тухай бүр илрүүлж урьдчилан сэргийлнэ	Г Г Г Г
2 дугаар зорилтын хүрээнд	<p>2.1. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, халдвар эсэргүүцэх арга хэмжээ, тандалт хийх эрүүл ахуйн халдвар хамгааллын дэглэмийн биелэлтэд хяналт тавих;</p> <p>2.2. Байгууллагын барилга байгууламж, өрөө тасалгаанд</p>	Алба хаагч, ажилчдын ажиллах ая тухтай орчин нөхцөл бүрдэнэ	Г Г,

	<p>өдөр тутмын болон үечилсэн эрүүл ахуй, халдвар судлалын хяналт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүр нь арилгуулах;</p> <p>2.3.Хлорамины болон жавелины уусмалаар ариутгал халдваргүйтгэл хийлгэх;</p>		Г,
3 дугаар зорилтын хүрээнд	<p>3.1.Офицер, ахлагч, ажилчдад эмнэлгийн идэвхтэй хяналтыг тасралтгүй тавих;</p> <p>3.2.Эмнэлэгт хэвтэн эмчлүүлж буй алба хаагч, ажилчдын биеийн байдал, эмчилгээний үр дүнгийн талаар байгууллагын удирдлагуудад илтгэн танилцуулж байх;</p>	<p>Алба хаагч ажилтанд эмнэлгийн анхан шат, нэгдүгээр шатлалын үйлчилгээг хүртээмжтэй хүргэснээр өвчлөлийг газар авхуулахгүй эмчлэх нөхцөл бүрдэнэ.</p>	Х, Х,
4 дүгээр зорилтын хүрээнд	<p>4.1.Албанд ашиглагдаж байгаа материал хэрэгсэл, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдалд үзлэг хийж, дутагдлыг арилгуулах, дүнг байгууллагын даргад илтгэх;</p> <p>4.2.Эм ороох боох материал, эмнэлгийн тоног төхөөрөмжийн урсгал болон нөөцийн стандартын дагуу бүрдүүлж хадгалалт хамгаалалтыг зөв зохион байгуулан сольж шинэчлэх ажлыг төлөвлөгөөний дагуу явуулах, нөхөн хангалт авах;</p> <p>4.3.Бие бүрэлдэхүүнийг эм ороох боох материалаар хангаж, хадгалалт ашиглалтад хяналт тавих;</p>	<p>Алба хаагч, ажилтны ажиллах ая тухтай нөхцөл бүрэлдэн өвчлөлийн үед бэлэн байдлын шаардлага хангагдана.</p>	Г, Г, Г,
5 дугаар зорилтын хүрээнд	<p>5.1.Бие бүрэлдэхүүнд мэргэжлийн байгууллагатай хамтран төрөл бүрийн сургалтыг зохион байгуулах;</p> <p>5.2.Офицер, ахлагч, ажилчдад эрүүл мэндийн боловсрол олгох сургалт сурталчилгааг явуулах.</p>	<p>Алба хаагч, ажилчдын эрүүл мэндийн боловсрол дээшилнэ.</p>	Т, Г,
6 дугаар зорилтын хүрээнд	<p>6.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлж, байгууллагын ажилтнууд болон харилцагч, үйлчлүүлэгчид, иргэдтэй зөв боловсон харьцах, ёс зүйн зөрчил, дутагдал гаргахгүй байх;</p> <p>6.2.Авлига, хүнд суртлаас ангид байж, хүний эрх, эрх чөлөөг</p>	<p>Цагдаагийн алба хаагчийн хуулиар хүлээлгэсэн нийтлэг чиг үүргийн биелэлт хангагдана.</p>	Г Г


хүндэтгэн шударга ёсыг эрхэмлэн "Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм"-ийг чанд мөрдөх; 6.3.Явцуу эрх ашиг сонирхлоос татгалзаж, цагдаагийн байгууллага, албаны нийтлэг эрх ашиг сонирхлыг эрхэмлэн ажиллах.		Г
---	--	---

III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА		
Боловсрол	-Дээд боловсролтой, Бакалавр ба түүнээс дээд түүнээс дээш боловсролтой байх	
Мэргэжил	-Анагаах ухаан /091201/	
Мэргэшил	-Шаардлагатай бол тухайн албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэргэжлийн чиглэлээр мэргэшсэн байх	
Туршлага	-Мэргэжлээрээ 2-оос доошгүй жил ажилласан -Цэргийн хэргийн мэдлэгтэй байх	
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	-Мэдээлэл дэх дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх -Гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах -Судалгааны ерөнхий арга зүйн мэдлэгтэй
	Асуудал шийдвэрлэх	-Өөрийн чиг үүргийн хүрээнд шийдлийн хувилбарыг боловсруулж, хариуцах -Шаардлагатай асуудлаар судалгаа хийж, дүнг хариуцах
	Багаар ажиллах	-Өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах -Бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох
	Бусад	-Гадаад хэл, мэдээллийн технологийн болон бусад зайлшгүй шаардлагатай ур чадвар

IV. АЛБАН ТУШААЛЫН ХАРИЛЦАХ СУБЪЕКТ	
Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр: - Алба, нэгж, нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын дарга. Захиргааны	
Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо: -Батлагдсан орон тоо.	Бусад харилцах субъект: Шууд харилцах байгууллага: -Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагуудын удирдлага, ахлах болон тооцооны нягтлан бодогч, эд хариуцагч, нярав, бусад алба хаагч нар. Шууд бус харилцах байгууллага: -Төрийн болон төрийн бус байгууллага, иргэн, аж ахуйн нэгж байгууллага. /Эдгээртэй харилцахдаа Цагдаагийн албаны тухай хууль, бусад хууль тогтоомж, үйл ажиллагааны журмын холбогдох заалтыг баримтална/.

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ:	
Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:

Албан тушаал:
ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДЭД ДАРГА, ЦАГДААГИЙН
ХУРАНДАА



Т.ГАНЗОРИГ

Байгууллагын нэр:
Шийдвэрийн огноо:
Дугаар:.....

2023 оны 11 дугаар сарын 27 ны өдөр

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр: ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
Шийдвэрийн огноо: 2023 оны 11 дугаар сарын 27 өдөр
Дугаар: 9/401

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА



Т.СҮХБОЛД

2023 оны 11 дугаар сарын 27 ны өдөр

Танилцсан:

Албан тушаал

.....

20 оны дугаар сарын -ны өдөр